



**БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/17

Хөхбүрд

Г Малчид, төлчид, тариаланчдын зөвлөгөөн Г
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/25 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн бодлого шийдвэр, холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан болон Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөр, аймаг, сумаас хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулах санал хүсэлт авч хэрэгжүүлэхээр малчид тариаланчдын зөвлөгөөнийг 2025 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсугай.

2.Малчид, төлчид, тариаланчидын зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах зардалыг Засаг даргын нөөц хөрөнгөөс 3,397,000 (Гурван сая гурван зуун ерэн долоо мянган) төгрөгөөр санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн), нягтлан бодогч (Л.Алимаа) нарт даалгасугай.

3.Зөвлөгөөн зохион байгуулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4.Дээрх ажлыг чанартай зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч нарт үүрэг болгосугай.


ДАРГА



БЯМБАДОРЖ

642401201

Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын
20-ны өдрийн 4/17 дугаар захирамжийн
хавсралт



**МАЛЧИД ТАРИАЛАНЧДЫН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭДДЭХҮҮН**

Мандалхайрхан 1 дүгээр баг

Ажлын хэсгийн ахлагч:(Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд:Л.Гүндцамба (Хөдөө аж ахуйн тасгийн дарга)

Б.Энх-Амгалан (Биеийн тамирын арга зүйч)

Уранхайрхан 2 дугаар баг

Ажлын хэсгийн ахлагч:(Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд:С.Өлзий-Орших (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

Э.Мөнхэрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

Асгамба 3 дугаар баг

Ажлын хэсгийн ахлагч:(Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Гишүүд:Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ж.Жамъяндагва (МЭТ-ийн Тархвар зүйч)

Мэргэн 4 дүгээр баг

Ажлын хэсгийн ахлагч:(Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүд:Б.Үлэмжсонин (Татварын Улсын байцаагч)

З.Ёндонжамц (Улсын бүртгэгч)



_____оОо_____